



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2012 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 72

Мандалговь

Хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 31 дүгээр зүйл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.2.е, 3.4, 4 дүгээр заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Тогтвортой амьжиргаа-2” төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг Аймгийн Засаг даргын тамгын газарт Samsung принтер- 1 ширхэг, Орон нутгийн өмчийн газарт Samsung принтер- 1 ширхэг, Шүүхийн шинжилгээний албанд Samsung принтер- 1 ширхэг, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрт Samsung принтер – 1 ширхэг, Биеийн тамир спортын газарт Samsung принтер – 1 ширхэг, Мэргэжлийн хяналтын газарт Samsung принтер – 2 ширхэг, Төв халхын дуулалт жүжгийн театрт Samsung принтер – 1 ширхэг, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд сандал - 5 ширхэг, дрож – 6 м.кв , зургийн аппарат – 1 ширхэг, Samsung принтер – 2 ширхэгийг дээрхи байгууллагуудад эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг зохих хууль журмын дагуу байгууллагын данс бүртгэлдээ бүртгэж авахыг Аймгийн Засаг даргын тамгын газар /Ц.Эрдэнэсүрэн/, Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/, Шүүхийн шинжилгээний алба /Б.Нарантуул/, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр /А.Ууганбаяр/, Биеийн тамир спортын газар /М.Наранбадрах/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Төв халхын дуулалт жүжгийн театр /Д.Доржсүрэн/, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа /Р.Баттүвшин/ нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцоожид үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ



Б.ДОРЖСҮМБЭР